



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 304/26

Улаанбаатар хот

Ээлжит бус нэгдсэн хуралдааны тов тогтох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 16 дугаар зүйлийн 16.8.3 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн гишүүний сул орон тоо болон Хяналтын зөвлөлийн гишүүний сул орон тоог нөхөх шалтгаанаар Ээлжит бус нэгдсэн хуралдааныг 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс 15-ны өдрийн хооронд зохион байгуулагдах “Tourism week” арга хэмжээний үеэр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Ээлжит бус нэгдсэн хуралдааныг зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж ажиллахыг Удирдах зөвлөлийн нарийн бичиг /Б.Жавхлан/, ажлын албанд даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН